

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО БА СОЁЛЫН ХӨГЖЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛ

Х.Мандухай *

Товч утга

Алив соёлын хөгжлийн үйл явц нь тухайн төр улсын бүтцийн задрал болон улс төрийн дэглэмийн уналт буюу өөрчлөлтөөр тасран саатдаггүй. Тэр л жам ёсоор Орос орны соёлын хөгжил явагдаж байгаа онцлогтой. Нөгөөтэйгүүр өнөөгийн Орос орон маш олон үндэстэн ястнаас бүрэлддэг тул тухайн үндэстний өвөрмөц соёл үйлчилж хөгжиж байгаа учир нэгдмэл нэг соёлын тухай яриа байх ёсгүй. Үүгээрээ Орос орны соёлын хөгжлийн онцлог байгаа юм. Орос орны соёл сүүлийн арав гаруй жилийн турш тус улсын өнгөрсөн үеийн түүхтэй салшгүй холбоотой явж ирэв. Гэхдээ улс төр, эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдал төрх, нөхцөл боломж иргэдийн үзэл санаа, оюун сэтгэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн учраас соёлын болон хүний хөгжлийн хүрээнд ч үлэмж нөлөөлсөн нь мэдээж юм. Хамгийн гол нь соёл урлагийн эрх чөлөө олж авсан явдал юм. Өөрөөр хэлбэл коммунист үзэл суртал, улс төрийн намын дарамт “боолчлолоос” чөлөөлөгдсөн явдал. Үүгээр Орос орны соёлын хөгжлийн өргөн дардан зам нээгдсэн бөгөөд түүний хөгжлийн хүчин зүйл нь хүний сайн сайхны үйл хэрэгт бодитой тус нэмэр болж байна.

Түлхүүр үг: Хүний хөгжил, үзэл баримтлал, ОХУ, нөхцөл байдал, соёлын бодлого

Нэг. Хүний хөгжлийн талаарх үзэл баримтлалын тухайд.

Хүн төрөлхтөн олон арван жилийн турш хөгжлийг авч үзэхдээ зөвхөн эдийн засгийн өсөлтийг анхаарч иржээ. Харин хүмүүн капиталыг өсөлтийн үйл явцын нэгээхэн хэсэг мэт үздэг байв. Өнгөрсөн хугацаанд аливаа улсын эдийн засгийн өсөлтийг

*Х.Мандухай – Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан, магистр

хангаснаар нийгмийн асуудлууд аяндаа шийдэгдэнэ гэсэн үзэл баримтлал давамгайлж ирсэн байдаг.

Гэвч түүхэн явцад улс орнуудад хичнээн эдийн засгийн өсөлт гарч, улс орнууд аж үйлдвэржсэн боловч тэнд ядуурал, тэгш бус байдал байсаар ирснийг олон улс орнуудын хөгжлийн туршлага харуулж байна. Иймээс эдийн засгийн өсөлтийг хүнд, хүний амьдралын чанарт хэрхэн яаж тусч байгаа талаас нь авч үзэх нь илүү чухал ач холбогдолтой болж байна. Тэгэхлээр хөгжил нь зөвхөн эдийн засгийн байдал биш харин хувь хүний болон нийгмийн тогтолцооны цогц бодлого гэж тодорхойлох нь сайн сайхан байдал, амьдралын чанар, утга учирт илүү нийцэх юм. Ерөөс хүний хөгжлийн тухай үзэл баримтлал нь Энэтхэгийн профессор, Нобелийн шагналтан Амарья Сений судалсан “Чадавхийн үзэл баримтлал”-д¹ суурилдаг байна. Хүний хөгжлийн үзэл баримтлал нь энгийн боловч маш хүчтэй үнэнг дэвшүүлсэн юм. Аливаа улс, үндэстний жинхэнэ баялаг бол хүмүүс билээ. Хүний хөгжлийн үзэл баримтлал нь хүмүүсийн амьдралын чанарыг анхаарлын төвд тавьснаар хөгжлийн хандлага, ойлголтыг өөрчилж байгаа юм.²

Хүний хөгжил гэдэг нь хүмүүс юу хийж чадах, хэн болохыг нь чухалчилдаг үзэл баримтлал бөгөөд аливаа улс үндэстний сайн сайхныг дан ганц эдийн засгийн өсөлтөөр хэмжихээс татгалзсан үзэл баримтлал юм.³ Хүний хөгжлийн үзэл баримтлал нь хөгжлийн төлөөх бүхий л үйл явцыг хамардаг бөгөөд үүнд эдийн засгийн өсөлт, технологи, нийгмийн суурь үйлчилгээ, төсвийн болон мөнгөний бодлого, олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт, ядууст чиглэсэн халамжийн сүлжээнүүд орно.

Хүний хөгжлийг хүмүүсийн эдийн засаг, улс төр, нийгэм болон соёлын бүх төрлийн сонголтуудыг өргөжүүлэх явц гэж тодорхойлдог. Зарчмын хувьд сонголтууд тодорхойгүй байж болох бөгөөд цаг хугацааны явцад ч өөрчлөгдөж болно. Судалгаанаас үзэхэд ихэнх тохиолдолд хүмүүс орлого юм уу тоогоор шууд харагддаггүй сонголтуудыг чухалчилдаг байна. Жишээлбэл, чөлөөт цагаа сэтгэл хангалуун өнгөрөөх, эрүүл мэндийн үйлчилгээ, мэдлэгийг чөлөөтэй эзэмших, улс төр, соёлын эрх чөлөө болон нийгмийн амьдралд оролцох зэргийг сонгох жишээтэй.

Хүний хөгжлийн үзэл баримтлалын үндсэн 5 зарчим байдаг. Үүнд:

1. Хүн бол хөгжлийн төвд байх ёстой,
2. Хөгжлийн зорилго нь зөвхөн орлогыг биш харин сонголтыг

О.Х.У: Хүний хөгжлийн бодлого ба соёлын хөгжлийн хүчин зүйл

өргөжүүлэхэд оршино.

3. Хүний хөгжил хоёр талтай. Нэгд, хүний чадвар, боломжийг хөгжүүлэхэд чиглэнэ. Эрүүл мэндийг сайжруулах, зөв хооллолт, мэдлэг, чадвар эзэмших асуудлууд багтана. Хоёрт, олж авсан чадвараа хэр бүрэн дүүрэн ашиглахад чиглэгдэнэ. Үүнд өсөн дэвжих, ажил хөдөлмөр эрхлэх, бүтээлч үйл ажиллагаа зэрэг асуудлууд багтаж байна.

4. Нийгэм бол хүний чадавх чадварыг хөгжүүлж, тэднийг аливаа боломжид эрх тэгш оролцох нөхцлөөр хангах учиртай.

5. Хүний хөгжлийн үндсэн 4 тулгуур нь эрх тэгш байдал, тогтвортой байдал, бүтээлч байдал, бие даасан байдал юм.⁴

Хөгжлийг хэмжихдээ хүмүүсийн амьдралын нөхцөл байдал, тэдний сонголт хийх эрх чөлөөг авч үзэхийн тулд юуны түрүүнд хүмүүс өөрийн амьдралдаа юуг өөрсдөө чухал гэж үздэгийг заавал бодолцох шаардлагатай.

Өөрөөр хэлбэл, шашин, соёл уламжлал, үндэсний бахархал, түүнчлэн хүний хөгжлийн индексэд бүрэлдэхүүн хэсэг болж ордог боловсрол, соёл, эрүүл мэнд зэрэг энэ бүх хүчин зүйлийг орлогын ач холбогдол өгөх шаардлагатай гэсэн үг.

Эдийн засгийн өсөлт, хүний хөгжлийн хоорондын ялгааг тодорхойлбол эдийн засгийн өсөлт нь цорын ганц орлогыг нэмэгдүүлэх сонголтонд анхаарал өгдөг бол хүний хөгжлийн үзэл баримтлал нь эдийн засаг, нийгэм, байгаль орчин, түүх, соёл, ёс заншил, улс төрийн гээд хүний бүхий л сонголтыг өргөжүүлэхэд анхаардаг. Тиймээс хүний хөгжил нь хүний сонголтын боломжуудыг эдийн засаг, нийгэм, соёл, улс төрийн бүхий л хүрээнд өргөжүүлэхийн зэрэгцээ сонголтын эрх тэгш байдлыг үүсгэнэ. Мөн хүний хөгжлийн загварын зорилго нь зах зээл, нийгмийн хүрээлэн, засаглалын тогтолцоо зэргийг зохистой уялдуулан хөгжүүлэх явдал юм.

Хоёр. Хүний хөгжлийн асуудал бол ОХУ-ын төрийн бодлогын тэргүүлэх чиглэл мөн.

Хүний хөгжлийг бүх талаар тэтгэх нь Орос улсын төрийн бодлогын нэг гол чиглэл юм. Хүн бүрийн хувийн бүтээлч чанар, боловсрол мэрэгжлийн түвшний дээшлэлт, бие даасан эрх чөлөөт байдалд тулгуурласан төрийн бодлого нь Орос оронд нийгмийн чиг баримжаатай хөгжлийн шинэ хэлбэрт шилжих, түүнийг төлөвшүүлэхэд үнэн чанартаа чиглэж байна гэж ОХУ-ын Засгийн газрын 2008 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 1662-р захирамжаар баталсан "ОХУ-ын нийгэм-эдийн засгийг 2020 он

хүртэлх урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал"-д онцлон дурджээ.⁵ Энэ бодлогыг нийгмийн бүхий л салбарт хэрэгжүүлэх гол хэлбэр нь хүний хөгжлийг хангах зорилтот хөтөлбөр юм. Энэ нь улс орны улс төр, нийгэм, эдийн засаг, соёлыг бүхэлд нь хамруулан зохицуулах харилцан уялдаатай, үр ашигтай хөгжлийг хангах үзэл баримтлалын стратегийн зорилгоос урган гарч буй аж. Урт хугацааны хэтийн ирээдүйтэй хөгжлийн нийгмийн чиг баримжаа бүхий хэлбэрийг бий болгоход зайлшгүй чухал орчин цагийн институцүүдийн тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай юм. Тийм институцүүдийн тогтолцоо нь дараах чиглэлийн хүрээнд бүрэлдэх аж. Үүнд:

1. Иргэний болон иргэдийн улс төрийн эрхийг хангах, тэрчлэн хууль ёсыг сахихад чиглэсэн улс төр эрхийн институцүүд. Хүний хувийн болон өмчийн халдашгүй эрх, хараат бус шүүх, хууль хамгаалах үр ашигтай тогтолцоо, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөт байдал зэрэг суурь эрхийг хамгаалах зэрэг бүтцүүд орно.

2. Хүний хөгжлийг хангах институцүүд. Үүнд юуны өмнө боловсрол, эрүүл мэнд, тэтгэврийн тогтолцоо, орон сууцны хангамж зэрэг салбарууд хамаарна. Эдгээр салбарын хөгжлийн зангилаа асуудлууд нь тэдгээрийн үйл ажиллагааны шинэ дүрэм журмуудыг боловсруулан институцийн шинэчлэлийг хэрэгжүүлэх явдал юм.

3. Эдийн засгийн институцүүд, өөрөөр хэлбэл, үндэсний эдийн засгийн хөгжил, тогтвортой үйл ажиллагааг хангах хууль эрхзүйн үндсийг бүрдүүлэх явдал гэж үзсэн байна.

4. Хөгжлийг хангахуйц, хөгжлийн эрх ашигт нийцсэн төсөв, мөнгөний бодлого, бүтэц, бүс нутаг, нийгмийн бодлогыг уялдуулахад чиглэсэн дээр дурьдсан институцүүдийг зохистой бүрдүүлэн хөгжүүлэх стратегийн удирдлагын тогтолцоо юм. Энэ бүхэн нь хүний хөгжлийн хангаж тэтгэх Оросын төрийн бодлогыг хэрэгжүүлэх гол гол хүчин зүйл болох ёстой аж.

Гурав. Орос орны соёлын хөгжлийн өнөөгийн хандлага, үйл явц.

XXI зууны эхэн Оросын нийгмийн амьдралд харьцангуй тогтвортой байдал бий болгосон бөгөөд тэр нь ЗСБНХУ-ын бутрал дээр илэрсэн соёлын хүрээний хандлагуудыг тодорхойлох боломж олгож байна.

Соёлын хөгжлийн үйл явц төр улсын бүтцийн задрал болон улс төрийн дэглэмийн уналтаар тасран саатдаггүй гэж үздэг. Орос орны соёл сүүлийн арав гаруй жилийн турш тус орны өнгөрсөн үеийн

О.Х.У: Хүний хөгжлийн бодлого ба соёлын хөгжлийн хүчин зүйл

түүхтэй салшгүй холбоотой явж ирэв. Тэхдээ улс төр, эдийн засаг, нийгмийн нөхцөл байдал иргэдийн үзэл санаа, оюун сэтгэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн учраас соёлын хүрээнд ч нөлөөлсөн нь мэдээж юм.

90-ээд оны эхээр төр соёлд өөрийн санааг тулган хүлээлгэдэг байсан үйлдлээ зогсоосон. Гэтэл үзэл суртлаас чөлөөлөгдөхийн хамт соёл өөрөө өөрийгөө хамгаалахаас өөр аргагүй болсон. Өөрөөр хэлбэл оршин тогтнох зарчим нь өөрчлөгдөж, цэвэр дидактик зарчмуудаас татгалзахад хүрснээс бүх нийтийн буюу дундаж хүмүүсийн хэрэглээний соёл хүмүүсийн нүд, чих, зүрхэнд хүрч эхэлсэн. Үүний зэрэгцээгээр <<Намын удирдан чиглүүлэх үүрэг>> Оросын амьдралаас хасагдсаны дараа нийгмийн өмнө ямар чиглэлээр хөгжих вэ гэдэг асуудал бий болж ирсэн. Эрдмийн хүрээ хангалттай өргөн, тухайлбал Өрнөдийн үлгэр жишээг судлахаас эхлээд Дорнод руу ч зүглэж баримжаалах болов. Энэ утгаараа Оросын нөхцөл байдал хосгүй байна гэж хэлж болно. Харилцаа холбооны хэрэгслийн хөгжлийн хэрээр соёлууд харилцан нэвтрэх нь ихсэж байна. Ийм үзэгдэл өнгөрсөн онуудад ажиглагдаж байсан. Гэвч энэ үзэгдэл сүүлийн жилүүдэд улам идэвхжээд соёлын глобализаци (даяарчлал) гэгдэх дээрээ хүрлээ. Углуу булан болгоноос сонсогддог <<глобализация>> гэдэг үгийг эдийн засагчид, улс төрчид бус харин жирийн хүмүүс чухамхүү соёлын даяарчлал болж байна хэмээн хүлээн авах болсон.

Үүнтэй зэрэгцээд соёлын жинхэнэ орос элементэд ч хамтын зөн билгийн ч байж болох бие биеэ дуурайх, ижилсэх хандлага нийгэмд үзэгдэх болов. XIX-XX зууны зааг дээр Европ соёлыг <<хүртэхийн ихээр хүртсэн>> хүн амын боловсролтой давхарга дахин Орос гэсэн, ардын гэсэн юм болгон руу тэмүүлэх болсон. Хавар болоход урт үстэй, жинтүү захтай цамц өмссөн залуучууд метронд үзэгдэх нь элбэгшсэн бөгөөд эрт балар цагийн Масленица, Иван Купчала гэх мэтийн тайлга тахилга үйлдэх нь ч олшров. Сүсэг бишрэл гэх үү! Орчин үеийн эдийн засгийн нөхцлийг харгалзан үзвэл энэхүү Оросжих эрмэлзлийг, гэгээн Валентины өдөр, гэгээн Патрикийн өдөр гэх мэтийн <<хөрөнгөтний>> баяраас салсны үр дүнд бий болсон үндэснийхээ ухамсарыг хадгалах гэсэн ээлжит <<их санаархал>> гэж үзэж болохгүй байх. Мөн нийтээрээ соёлын ач тусыг амсах боломжгүй жирийн хүмүүсийн чөлөөт цагаа өнгөрөөх ганц боломжийн хэлбэр нь ардын баяр цэнгэл мөн билээ. Гэр бүлээрээ, найз нөхдөөрөө цэвэр агаарт гарч ардын тоглоом наадамд орслоож блина, медавух амсах, түүдэг гал дээгүүр харайж

наадахаас дургүйцэх хүн байна гэж үү?

Телевизүүд биеэ даах болсноос үзэгчдийн сонирхол татах сайн нэвтрүүлгээр эфирээ дүүргэх хэрэгтэй болсон, тэгсэн цагт телевизийн рейтинг өсөж байна. Жишээ нь: боловсролын гэх мэт нэвтрүүлгийг бодвол зугаацуулах нэвтрүүлгүүд үзэгчдийн анхаарлыг илүү татдаг нь мэдээж юм. Тиймээс сувгуудын ихэнх нь зугаатай нэвтрүүлгээр зуун хувь дүүрэх болов. Бие биеэсээ ялгагдахгүй тоо тоомшгүй олон шоуунууд нэвтрүүлгийн хамаг цагийг эзлэх боллоо. Бүх хүний дурладаг латин америкийн олон ангит кинонууд ч явцгүй болов. Яагаад гэвэл тэдний кинонуудын үйл явдал эрүүл ухаантай хүний толгойд багтахгүй байв. Гэрийн эзэгтэй нар бол тун сонирхолтой үзэгчид байж болох юм гэдгийг ойлгосон олон рекламчид болон теле зүтгэлтнүүд айлын голомт сахигчдыг уйдаахгүйн талаар уралдаж эхэлсэн. Ток-шоу, олон ангит кино үзэхийн завсар борш (украйн шөл) чанахад амттай, тоос шороо цэвэрлэхэд ч сайн болдог гэдэгт эргэлзэх хүн байхгүй болов. Бас ажлын дараа ядарсан үзэгчдийг сэтгэл санаагаар дэмжих нэвтрүүлэг хэрэгтэй гэдэг дүгнэлтэд хүрчээ.

Хэрвээ зөвлөлт засгийн үед бүх хүнд зориулсан нэг нэвтрүүлэг явуулдаг байсан бол одоо нэвтрүүлгийн хөтөлбөр тодорхой хэсэг хүмүүст зориулагдах болов. Сүүлийн ганц хоёр жилд хүн бүхэнд тохирох телевизийн бүтээл гаргах хандлага бий болсныг хэлэх хэрэгтэй. (Жишээ нь <<Московская сага>>, <<Идиот>>) гэх мэтийн кинонууд рейтинг тодорхойлогчид ч, эмнэлгийн үүдэнд ч, их дээд сургуулиудын танхимуудад ч, офисын тамхины өрөөнүүдэд ч адилхан хэлцэгдэх болсон. Гэвч оюуны нэгдлийн иймэрхүү жишээ байгаа ч гэсэн олон нийтийн мэдээллийн хэрэгсэл хүн амд оюун санааны стратификаци нөлөө үзүүлж байна гэдэг сэтгэгдэл төрдөг. Зах зээлийн харилцаа тогтосноор зөвлөлт засгийн үед иргэд идэвх муутай байсан явдал эцэс болсон. <<Цэрэг унтаж байхад албаны хугацаа хорогдож байдаг>> гэдэг зарчим <<чоно хөлийн хурдаар амиа тэжээдэг>> гэдэг зарчмаар солигдсон. Тийм учраас эдийн засгийн талаар идэвхтэй иргэнд олон нийтийн арга хэмжээ, хурал цуглаан мэтэд очих цаг олдохоо больсон. Цаг наргүй ажил хийсний дараа өөрт ямарч ашиггүй гудамжны цуглаанд оролцох сонирхол түүнд байхгүй. Тэгэхлээр улс төрд оюутнууд, тэтгэврийхний зугаацал болдог бол бусад нь улс төрийг тоохоо болиод концерт, орен-эйрах, хөгжмийн наадам зэрэг улс төрийн бус арга хэмжээг сонирхох болсон.

Хөгжмийн төрөлжсөн теле сувгууд, FM радио станцууд

О.Х.У: Хүний хөгжлийн бодлого ба соёлын хөгжлийн хүчин Зүйл

бий болсноор хөгжмийн бүтээлүүдийг <<формат>> ба <<не формат>> гэдэг зарчмаар хуваах болсон. <<Формат>>-д багтах эрмэлзлэлтэй хөгжимчид буулт хийх ёстой. Үүнд рокерууд попс болж, рокпопс гэдэг ухагдахуун бий болсон. Поп-ыг баримтлагчид савхин хүрмийг, гитарын нумыг ч голохгүй. Дуурийн дуучид шоу-бизнесийн одод болон хувирав. Хөгжмийн хүрээнд болж байгаа үйл явцыг мэйнстризмын хязгааргүй өсөлт гэж тодорхойлж болох бол номын хувьд өөр байна. Зөвлөлт засгийн үед үзэл сурталд нийцэхгүй байсан, одоогийн томьёоллоор бол <<неформат>> зохиол хэвлэгддэггүй байсан бол одоо аль аль нь хэвлэгдэж байна. Ном ховордох явдлыг эцэс болгосон энэ үзэгдэл ховор нандин агуулгатай номууд алга болоход хүргэсэн бололтой. Сайн ном ховор байсан. Гэвч олигтойхон номын сангууд үеийн үед тэдгээрийг цуглуулсаар байжээ. Өрнөд ертөнцөөс олон жилээр хоцорсноо нөхөж, өрнөд ертөнцөд аль хэдийнээ сонгодог бол зуу зуун зохиолчидтой орос уншигчид сая танилцаж байхад хэвлэлээс хэвлэл их өрнөсөн явдал жирийн уншигчид номын дэлгүүрийн удам их орчинд учраа олоход хэцүүхэн болж иржээ. Ийм тохиолдолд телевизийн шинэ номын тухай нэвтрүүлгүүд, гял цал сэтгүүлүүдийн шинэ номын тухай булангууд тэдэнд тус болж эхэлжээ. Тэрч байтугай амралтанд болон <<метрон>> дотор уншихад зориулсан гэх номууд бий болсон. Тэдгээрийн хэлбэр хэмжээ хүртэл өвөрмөц, халаасанд буюу эмэгтэй хүний жижиг цүнхэнд ч багтана. Тийм номуудын агуулга нь уураг тархинд хүндрэл учруулхааргүй, найруулга нь энгийн, үйл явдал нь сонирхолтой байдаг. Тиймэрхүү номуудыг хоёрдохоо унших шаардлага гарахгүй учраас тэдгээрийг уншаад урчихдаг сонинтой адилтгаж болмоор. Ном олдох муутайгаас бус аль хэдэн жилийн хугацаанд ач холбогдлоо алдахгүй бол аль нь цаасны хогт тушаагдах бол гэдгийг ялган салгахад хэцүү болсон учраас номын санд ном сонгох хэцүү болжээ.

Орчин үеийн нийгмийн амьдралд цоо шинээр гарч ирсэн интернэт хэмээх гоц үзэгдлийн тухай дурдахгүй өнгөрч болохгүй билээ. Орчин цагийн соёлд Интернэт ямар ач холбогдолтойг хэтрүүлэн үнэлэх боломжгүй. Учир нь Интернэт бол харилцааны хосгүй хэрэгсэл, мэдээлэл хадгалах зүйл мөн бөгөөд тэр нь соёлыг олон түмэнд нэн хүртээмжтэй, ардчилсан шинжтэй болгохоос гадна соёл ба урлагийн бодит ертөнцөд зохицох муутай олон чиглэлд хөгжих боломж олгоно. Зах хязгаар нутагт Интернэт онцгой ач холбогдолтой. Үүнд Орос орны төв хэсгийн гадна орших жижиг хотуудын, том хотуудын ч хүмүүс нийслэлийн ба ер нь бүх дэлхийн

соёлын амьдралд оролцох боломжтой боллоо.

Орчин үеийн шинжлэх ухаан технологи (ШУТ)-ийн дэвшлийн ололтыг ашиглан соёлын үнэт зүйлс, өв уламжлал, бүтээлийг нийгмийн хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх, нийтийн хүртээл болгон, хэрэглээний эргэлтэнд оруулах үйл ажиллагаа инновацитай салшгүй холбоотой. Иймээс дэлхий дахинд соёл урлагийн салбарт ШУТ-ийн дэвшлийг өргөнөөр нэвтрүүлж, инновацийг хэрэгжүүлснээр соёлын үйлдвэрлэлийн эрчимтэй хөгжилд томоохон түлхэц үзүүлсэн билээ.

Инноваци нь шинжлэх ухаан боловсрол бизнесийн уялдаа холбоог хангах гол арга хэрэгсэл болж байна. 2012 онд батлагдсан ОХУ-ын Инновацийн тухай хуульд “Инноваци гэдэг нь мэдлэгийг баялаг болгон хувиргах цогц үйл ажиллагаа” хэмээн тодорхойлжээ. Соёл ба инновацийн уялдаа холбооны тухайд гэвэл тэр нь соёлын инноваци, инновацийн соёл гэсэн ойлголтуудаар илэрхийлэгддэг. Соёлын инновацийн хувьд соёл урлагийн болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбар ШУТ-ийн дэвшлийг нэвтрүүлэхтэй холбоотой бол инновацийн соёл гэдэгт инновацийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага, субъектүүдийн идэвхжил, шинэ зүйлд мэдрэмжтэй байдал, олон нийтийн инновацийн мэдлэг, хүн амын бизнесийн болон инновацийн сэтгэлгээний хөгжил, бүтээлч байдал, улс төрийн нам, хүчнүүд, лидерүүдийн хандлага, хүсэл зориг зэргийг хамруулан авч үзэж байна.

Ийнхүү одоо XXI зууны эхэнд соёлын хөгжлийн ямар нэгэн үндсэн чиглэлийг онцгойлон тодруулах боломжгүй байна Энэ зуунд Орос орон ямар ч чиглэлээр хөгжсөн Орос соёл тус орны гол баялаг, үндэсний нэгдлийн баталгаа байх болно.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ:

¹ www.mkrf.ru

² Концепция Федеральной целевой программы “Культура России (2012-2018 годы)”.

³ Амаръя Сени (Индия) “Концепция человеческого капитала”, м., 2004

⁴ www.tvoimir.ru/kultura_rossii.shtml

⁵ Л.Оюунцэцэг, Үндэсний инновацийн тогтолцоо бүрдүүлэх онол-арга зүйн үндэс. ЭЗШУ Докторын зэрэг горилсон бүтээл. 2009 он УБ

⁶ www.history4you.ru/lessons/vulture/show-lesson/-/asset_publisher/

⁷ Концепция национального развития Российской Федерации.
м., 2011

⁸ www.fcpkultura.ru/new.php?id=8

Abstract:

The major wealth of any nation is its people. So the man must be in center of all development. For decades, the human development has focused on the economic growth. However, there is a high economic growth, and industrialized in any nation, eventually, the development experience of many countries indicates that there are still poverty and inequality. Therefore, the human development is not only the economic state but it is better to define that this is a complex policy of social system, individual's living capacity and life ability as well. Hereinafter, I tried to write in this article how the cultural development will impact on the human development.

Key Words: Human development, concept, RF, state, leading trends, cultural policy, development, issue